



ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН МЭДЭЭЛЭЛ, ДҮН ШИНЖИЛГЭЭ, ШУУРХАЙ УДИРДЛАГЫН АЛБА

2021 оны 10 дугаар
сарын 08-ны өдөр

№ 80


Улаанбаатар
хот

НАСАНД ХҮРЭЭГҮЙ ХҮҮХДЭЭС ҮЙЛДСЭН БОЛОН ӨРТӨЖ ХОХИРСОН ГЭМТ ХЭРГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Монгол улсад сүүлийн 5 жилд бүртгэгдсэн насанд хүрээгүй хүүхдээс үйлдсэн болон өртөж хохирсон гэмт хэргийн статистик тоо баримт, нөхцөл байдалд хийсэн хэсэгчилсэн дүн шинжилгээний дүнг танилцуулж байна.

Нэг. Хүүхэд хохирсон гэмт хэргийн нөхцөл байдал

Улсын хэмжээнд 2016-2020 онд нийт 150.234 гэмт хэрэг бүртгэгдсэний 7346 буюу 4.9 хувь нь хүүхэд хохирсон гэмт хэрэг эзэлж байгаагаас 4649 буюу 63.3 хувь нь нийслэлд, 2697 буюу 36.7 хувь нь орон нутагт бүртгэгджээ.



Зураг. Хүүхэд хохирсон гэмт хэрэг /2016-2020 он/

Хүүхэд хохирсон гэмт хэргийг өмнөх онтой нь харьцуулвал 2017 онд 403 буюу 31.3 хувиар өсч, 2018 онд 34 буюу 2.0 хувиар, 2019 онд 103 буюу 6.2 хувиар, 2020 онд 398 буюу 25.6 хувиар тус тус буурсан байна.

Мөн энэ оны эхний 09 дүгээр сард бүртгэгдсэн гэмт хэрэг өмнөх оны мөн үеэс 39 буюу 4.4 хувиар буурчээ.


Хүснэгт. Хүүхэд өртөж хохирсон гэмт хэргийн төрөл /2016-2020 он/

№	Эрүүгийн хуулийн зүйл анги	Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг /ЭХ-ийн 91-95/	Үүнээс:		Бусдын бие махбодид гэмтэл учруулах /ЭХ-96-100/	Хүчиндэх /ЭХ-126/	Бусдын эд хөрөнгийг хулгайлах /ЭХ-145/	Бусдын эд хөрөнгийг дээрэмдэх /ЭХ-147/	ТХХА БАЖ эсрэг гэмт хэрэг /ЭХ-215-225/	Бусад төрлийн	Нийт
			Хүнийг санаатай алах /ЭХ-91/								
Эрүүгийн хууль /2012 онд батлагдсан/											
1	2016 он	47	2		318	136	134	114	260	279	1288
2	2017.I-VI сар	38	7		180	72	71	61	117	168	707
Эрүүгийн хууль /2017 онд батлагдсан/											

№	Эрүүгийн хуулийн зүйл анги Он	Хүний амьд явах эрхийн эсрэг / ЭХ-10.1-10.5/	Үүнээс:	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг	Үүнээс	Хүчindэх / ЭХ-12.1/	Бэлгийн мөлжлөг / ЭХ-12.3/	Хулгайлах /ЭХ-17.1/	Дээрэмдэх / ЭХ-17.2/	ХАБТХАЖ-ын эсрэг	Бусад төрлийн	Нийт
			Хүнийг алах / ЭХ-10.1/		Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх /ЭХ-11.7/							
3	2017.VII-XII сар	34	1	226	12	111	2	119	232	117	143	984
4	2018 он	47	3	435	19	235	1	291	213	182	253	1657
5	2019 он	60	4	493	5	247	4	154	130	194	272	1554
6	2020 он	34	8	420	12	243	2	89	57	149	162	1156
5 жилийн дүн		260	25	2013	36	934	7	937	895	1143	1406	7346
Эзлэх хувь		3.5	0.3	28.2	0.7	14.2	2.9	11.3	13.7	8.7	17.4	100%


Сүүлийн 5 жилд хүүхэд хохирсон гэмт хэргийн 28.2 хувь нь хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг, 11.3 хувь нь хулгайлах, 13.7 хувь нь дээрэмдэх, 8.7 хувь нь хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгсэл ашиглалтын журмын эсрэг, 17.4 хувь нь бусад төрлийн гэмт хэргүүд эзэлж байна.

Зураг. Хүүхэд өртөж хохирсон хэрэг үйлдэгдсэн гараг /2016-2020 он/




Хүүхэд өртөж хохирсон гэмт хэрэг үйлдэгдсэн гарагаар тооцож үзвэл, 2308 буюу 31.4 хувь нь даваа, мягмар гарагт хамгийн олон бүртгэгдсэн бол 1774 буюу 21.2 хувь нь бямба, ням гарагуудад хамгийн бага бүртгэгджээ.

Зураг. Хүүхэд өртөж хохирсон гэмт хэрэг үйлдэгдсэн цаг хугацаа /2016-2020 он/



Хүүхэд өртөж хохирсон гэмт хэрэг үйлдэгдсэн цаг хугацаагаар тооцож үзвэл, 2751 буюу 37.5 хувь нь 14.00-19.00 цагт хамгийн олон бүртгэгдсэн бол 1308 буюу 17.8 хувь нь 19.00-22.00 цагт хамгийн бага бүртгэгджээ.

Зураг. Хүүхэд өртөж хохирсон гэмт хэрэг үйлдэгдсэн газар /2016-2020 он/



Хүүхэд өртөж хохирсон хэрэг үйлдэгдсэн газраар нь авч үзвэл 2232 буюу 30.4 хувь нь гэр, орон сууцанд, 2181 буюу 29.7 хувь нь гудамж талбай, авто зам дээр үйлдэгджээ.


1.1. Гэмт хэргийн улмаас хохирсон хүүхэд

Гэмт хэргийн улмаас 2016 онд 1340, 2017 онд 1757, 2018 онд 1688, 2019 онд 1598, 2020 онд 1181, нийт 7564 хүүхэд хохирсон байна.

Зураг. Гэмт хэргийн улмаас хохирсон хүүхэд /2016-2020 он/




Зураг. Гэмт хэргийн улмаас хохирсон хүүхэд /хүйсээр/



Сүүлийн 5 жилийн хугацаанд /2016-2020 онд/ гэмт хэргийн улмаас хохирсон хүүхдийн 62.9 хувь нийслэлд, 37.1 хувь нь орон нутагт, 3364 буюу 44.5 хувь нь эмэгтэй хүүхэд эзэлж байна.

Гэмт хэргийн улмаас 7564 хүүхэд хохирсноос 955 буюу 12.6 хувь нь 0-7 хүртэлх насны, 2189 буюу 28.9 хувь нь 8-13 насны, 4420 буюу 58.4 хувь нь 14-17 насны хүүхэд байна.


Зураг. Хүүхэд нас барсан гэмт хэргийн төрөл /өсөлт, бууралт/



Энэ хугацаанд гэмт хэргийн улмаас нас барсан хүүхдүүдийг Эрүүгийн хуульд заасан гэмт хэргийн төрлөөр нь авч үзвэл 26 буюу 4.8 хувь нь хүнийг алах, 77 буюу 14.3 хувь нь хүний амь насыг болгоомжгүй хохироох, 118 буюу 22.0 хувь нь хүнийг амиа хорлох нөхцөл байдал хүргэх, 254 буюу 47.3 хувь нь хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг, 62 буюу 11.5 хувь нь бусад төрлийн гэмт хэргийн улмаас нас баржээ.

Гэмт хэргийн улмаас нийт 537 хүүхэд нас барснаас 348 буюу 64.8 хувь нь 7 хүртэлх насны, 97 буюу 18.1 хувь нь 8-13 насны, 92 буюу 17.1 хувь нь 14-17 насны хүүхэд байна.

Зураг. Хүүхэд гэмтсэн гэмт хэргийн төрөл /өсөлт, бууралт/



Гэмт хэргийн улмаас гэмтсэн хүүхдийг Эрүүгийн хуульд заасан гэмт хэргийн төрлөөр нь ангилан үзвэл 135 буюу 4.3 хувь нь хүчиндэх, 82 буюу 2.6 хувь нь олон нийтийн амгалан тайван байдал алдагдуулах, 803 буюу 25.4 хувь нь хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг, 1879 буюу 59.5 хувь нь хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг, 261 буюу 8.3 хувь нь бусад төрлийн гэмт хэргийн хохирогч болжээ.

Хоёр. Насанд хүрээгүй хүүхдээс үйлдсэн гэмт хэргийн нөхцөл байдал

Улсын хэмжээнд сүүлийн 5 жилийн хугацаанд /2016-2020 онд/ нийт 150.234 гэмт хэрэг бүртгэгдсэний 4417 буюу 3.0 хувь нь насанд хүрээгүй хүний үйлдсэн гэмт хэрэг эзэлж байгаагаас 2665 буюу 60.3 хувь нь нийслэлд, 1752 буюу 39.7 хувь нь орон нутагт бүртгэгджээ.

Энэ оны эхний 09 дүгээр сард бүртгэгдсэн нийт 17350 гэмт хэргийн 451 буюу 2.6 хувийг хүүхэд оролцож үйлдсэн хэрэг эзэлж байна.

Зураг. Насанд хүрээгүй хүний үйлдсэн гэмт хэрэг /2016-2020 он/



Энэ оны эхний 9 дүгээр сарын байдлаар гэмт хэрэгт холбогдогчдын 542 буюу 4.6 хувийг хүүхэд эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеэс 46 буюу 7.8 хувиар буурсан байна.


Хүснэгт. Насанд хүрээгүй хүнээс үйлдсэн гэмт хэргийн төрөл

Гэмт хэргийн төрөл	Хэргийн тоо					Эзлэх хувь
	2016 он	2017 он	2018 он	2019 он	2020 он	
Хүнийг алах	2	5	1	4	1	0.3
Амиа хорлох нөхцөл байдалд хүргэх			1		1	0.0
Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг	173	187	185	232	224	22.7
Хүчиндэх	19	20	22	16	20	2.2
Хулгайлах	529	411	356	567	355	49.8
Залилах	42	32	40	97	69	6.3
Дээрэмдэх	83	100	68	64	43	8.1
Олон нийтийн амгалан тайван байдал алдагдуулах	35	33	2	2	0	1.6
Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах		8	10	10	9	0.8
Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг	18	8	13	19	9	1.5
Бусад төрлийн гэмт хэрэг	52	40	43	57	79	6.1
Нийт	953	844	741	1068	811	


Гэмт хэрэг үйлдсэн насанд хүрээгүй хүний 304 буюу 6.8 хувь нь согтуугаар үйлдсэн байна.

Гэмт хэрэг үйлдсэн гараг, цаг хугацаагаар нь тооцож үзвэл 1495 буюу 35.1 хувь нь 22.00-06.00 цагт, 1354 буюу 30.5 хувь нь даваа, баасан гарагт хамгийн олон үйлдэгджээ.

Зураг. Гэмт хэрэг үйлдэгдсэн гараг, цаг хугацаа /2016-2020 он/



Зураг. Гэмт хэрэг үйлдэгдсэн газар /2016-2020 он/



Насанд хүрээгүй хүний гэмт хэрэг үйлдсэн газраар нь авч үзвэл 1414 буюу 32.0 хувь нь гудамж талбай, 785 буюу 17.8 хувь нь олон нийтийн газарт, 1254 буюу 28.4 хувь нь гэр, орон сууцанд үйлдэгджээ.

1.2. Гэмт хэрэг үйлдсэн насанд хүрээгүй хүний талаар

Сүүлийн 5 жилийн хугацаанд 4417 хэрэгт насанд хүрээгүй 5533 хүн холбогдон шалгагдсанаас 2071 буюу 37.4 хувь нь 14-15 насны, 3462 хувь нь 62.6 хувь 16-17 насныхан эзэлж байна. Энэ оны эхний 9 дүгээр сарын байдлаар 16-17 насны 354, 15 хүртлэх насны 188 хүүхэд гэмт хэрэгт холбогджээ.


1.3. Насанд хүрээгүй хүнээс үйлдэгдсэн гэмт хэргийн нөхцөл байдлын төсөөлөл /2040 он хүртэл/

Насанд хүрээгүй хүнээс үйлдэгдсэн гэмт хэргийн сүүлийн 10 жилд /2011-2020/ бүртгэгдсэн тоон мэдээнд үндэслэн энэ хүү төсөөллийг “Vensim Програм” хангамж дээр симуляц хийж үзэхэд Улсын хэмжээнд 2020 онд 811 гэмт хэрэг бүртгэгдэж байсан бол 2040 онд 1245 гэмт хэрэг бүртгэгдэх бөгөөд жилд дунджаар 1.7 хувиар өсөх төлөвтэй байна.




Тайлбар: Current цэнхэр шугам нь ямар нэгэн нөлөөлөл оруулаагүй ирээдүйн өсөлт

Мөн Монгол Улсын ядуурлын төвшин, архины хэрэглээг багасгаж симуляц хийж үзэхийн тулд 0,249 байсан ядуурлын төвшинг 0,200 болгоход 2040 онд 0.825 хувиар, архины нэг хүнд ноогдох хэрэглээг 10 литрээр багасгаж үзэхэд 2040 онд 1.342 хувиар буурах төлөв гарч байна.



Тайлбар: Улаан шугам нь ямар нэгэн нөлөөлөл оруулаагүй ирээдүйн өсөлт
Цэнхэр шугам нь - ядуурлын төвшинг багасгасан төсөөлөл



Тайлбар: Улаан шугам нь ямар нэгэн нөлөөлөл оруулаагүй ирээдүйн өсөлт.
Цэнхэр шугам нь архины хэрэглээг багасгасан төсөөлөл

Гурав. Хүүхдийг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр хэрэгжүүлсэн зарим ажил, арга хэмжээний талаар

Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 270 дугаар тогтоолоор баталсан “Хүүхдийн хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөр” /2018-2020 он/, 2018 оны 163 дугаар тогтоолоор баталсан “Осол, гэмтлээс урьдчилан сэргийлэх үндэсний

хөтөлбөр” /2018-2022 он/, ЦЕГ-ын даргын 2021 оны А/60 дугаар тушаалаар шинэчлэн батлагдсан “Хүүхдийн эрхийг хангах журам /Код-316/”-ийн хэрэгжилтийг ханган ажилласан байна.

Энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх бодлого, чиглэлийг тодорхойлж, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, үйл ажиллагааг эрчимжүүлэх чиглэлээр Цагдаагийн ерөнхий газрын даргын 2020 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн А/316 дугаар “Нэршил өөрчилж, орон тоо намэх, шилжүүлэх тухай” тушаалаар Цагдаагийн ерөнхий газрын “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хэлтэс”-ийн нэршлийг “Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэс” болгон чиг үүргийн бүтэц, зохион байгуулалтыг шинэчлэн баталж, хүүхдээс үйлдсэн болон хүүхэд хохирсон гэмт хэрэг мөрдөн шалгах мөрдөгч, хүүхдийн асуудал хариуцсан 103 алба хаагчдын орон тоог шинээр нэмж үйл ажиллагааг нь жигдрүүлсэн байна.

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2021 оны Б/199 дугаар тушаалаар шинээр томилогдсон алба хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, мэргэшүүлэх цахим сургалтыг энэ оны 02 дугаар сарын 25, 26-ны өдрүүдэд зохион байгуулж, төв, орон нутгийн цагдаагийн газар, хэлтсийн 178 алба хаагчийг хамруулжээ.

Хүүхдийг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, ухуулга нөлөөллийн болон гэр бүлийн хүчирхийллийн хор уршгийн талаарх иргэдийн мэдлэгийг дээшлүүлж, гэр бүлийн харилцааны сөрөг хандлага, зан төлөвийг өөрчлөх, эерэг мэдээллийг өгч хүчирхийллийг үл тэвчих нийгмийн хандлагыг төлөвшүүлэх, нуугдмал гэмт хэрэг, зөрчлийг илрүүлэх, хохирогчийн эрх, хууль ёсны ашиг, сонирхлыг хамгаалах чиглэлээр “UNFRIEND хөдөлгөөн”, “Цахим орчин зөв бол Гоё”, “Зөв тусгал”, “Хичээлийн шинэ жил”, “Сүүдэр бүү тусгс”, “Хуулиа мөрдье-21”, “Хайрла хамгаал”, “Зуслан”, “Хэрсүү гурвалжин”, “Хүүхэд хамгаалал”, “Хичээл эхэллээ” зэрэг арга арга хэмжээнүүдийг улсын хэмжээнд зохион байгуулж үр дүнг тооцон ажилласан.

Монгол Улсад Хууль зүйн алба үүсэн байгуулагдсаны 110, орчин цагийн Цагдаагийн байгууллага үүсэн байгуулагдсаны 100 жилийн ойг тохиолдуулан цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа, бахархал, алба хаагчийн ажил үйлс, гавьяа зүтгэлийг хүүхдийн уран бүтээлээр дамжуулан олон нийтэд таниулан сурталчлах зорилготой “Бидний баатар цагдаа” уран зургийн уралдааныг Монголын Хүүхдийн Урлан Бүтээх төвтэй хамтран зохион явуулж, хүүхдүүдийн зурсан 646 уран бүтээлийг хүлээн авч, шагнал урамшуулал олгож, фэйсбүүк цахим хуудаст байршуулан хүүхэд, залуучууд, олон нийтэд сурталчилсан байна.

Хүүхдийг сургууль, гэрийн хооронд ирж, буцах замдаа аливаа осол гэмтэл, гэмт хэрэг, зөрчилд өртөж хохироос урьдчилан сэргийлэх, эмзэг цэгүүдэд хяналт тавих, аюулгүй зорчуулах, ахмад настны хөдөлмөрийг дэмжих зорилгоор “Хүүхэд хамгаалагч” төслийг цагдаагийн байгууллагаас санаачлан 2018, 2019 онд туршилтаар, 2020, 2021 онд үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээр аймаг, нийслэлд 214 хүүхэд хамгаалагчийг ажиллуулхаар энэ онд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын А/90, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын А/132 дугаар тушаалаар “Хүүхэд хамгаалагч” төслийн төсөв /254,016,000 төг/ батлагдаж, төсвийн хуваарийг аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтсүүдэд хүргүүлсэн хэдий ч короновирусийн халдварын нөхцөл байдлын улмаас төсөл хэрэгжүүлэх ерөнхий чиглэл ирээгүй, 4 аймаг, 5 дүүрэг дотоод зохион байгуулалтаараа 2-4 сарын хугацаанд 89 хүүхэд хамгаалагчийг ажиллуулсан байна.

Хууль зүй, дотоод хэргийн сайд, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд нарын 2017 оны А/253, А/252 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан “Өсвөрийн сэргийлэгч сайн дурын бүлгэм ажиллах журам”-ын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд ерөнхий боловсролын 476 сургуулийн “Өсвөрийн сэргийлэгч бүлгэм”-ийн үйл ажиллагааг идэвхжүүлж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, 7 бүлгэмийн үйл ажиллагааг шинэчлэн зохион байгуулжээ.

Ерөнхий боловсролын сургуулийн орчинд сурагчид гэмт хэрэг, зөрчилд холбогдох, өртөж хохирохоос урьдчилан сэргийлэхэд эцэг, эх, багш, сурган хүмүүжүүлэгчдийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор “School police” төслийг 6 дахь жилдээ амжилттай хэрэгжүүлж, энэ онд “School police”, “Kinder police” эргүүлд 4.670 эцэг эх, асран хамгаалагчийг хуваарийн дагуу 854 ерөнхий боловсролын сургууль, 770 цэцэрлэгийн орчинд ажиллуулж, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлсэн.

Засгийн газрын 2018 оны 163 дугаар тогтоолоор батлагдсан “Осол гэмтлээс сэргийлэх” үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангуулах, Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, иргэдийн эрх зүйн мэдлэг боловсрол, эцэг эх, асран хамгаалагчдын үүрэг хариуцлагыг дээшлүүлэх, тээврийн хэрэгслээр хүүхдийг аюулгүй зөв тээвэрлэх, цагдаагийн байгууллагаас хэрэгжүүлж буй ажил, арга хэмжээг иргэд, олон нийтэд сурталчлах зорилгоор “Бяцхан зорчигч”, “Хурд”, “Хамгаалах бүс”, “Нэг хором хүлээ” зэрэг нэгдсэн арга хэмжээнүүдийг зохион явуулж, “Гэрлээ асаасанд баярлалаа”, “Гэрэлт ирээдүйнхээ төлөө гэрлээ асаацгаая” уриалга гаргажээ.

Дөрөв. Дүгнэлт

1. Цагдаагийн байгууллагын бүтэц, зохион байгуулалтад өөрчлөлт оруулж Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийг байгуулж, нэгдсэн бодлого, төлөвлөлтөөр удирдан зохион байгуулсны үр дүн, мөн дэлхий нийтийг цочирдуулсан коронавирусийн халдварт цар тахлаас үүссэн хөл хорио, хязгаарлалтын дэглэм, нийгэм, эдийн засгийн бусад нөлөөлөл, хүчин зүйлээс хамаарч хүүхэд хохирсон гэмт хэрэг сүүлийн 3 жил дараалан 2.0-25.6 хувиар, 2021 оны эхний 09 сарын байдлаар 4.4 хувиар, насанд хүрээгүй хүнээс үйлдсэн гэмт хэрэг 2020 онд 24.0 хувиар, 2021 оны эхний 09 сарын байдлаар 7.8 хувиар тус тус буурчээ.

2. Монгол улсын Засгийн газар, Улсын онцгой комиссоос тогтоосон хорио цээрийн дэглэм, зарим хязгаарлалтын арга хэмжээ авч хэрэгжүүлсэн үед цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг тогтмол өсч байгаа нь иргэд /хүүхдийн/-ийн цахим хэрэглээ нэмэгдсэнтэй шууд холбоотой байна. Нөгөө талаас иргэдийн орлого буурсан, нийгмийн сэтгэл зүй тогтворгүй байгаагаас гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх, ахуйн хүрээний архидалтын улмаас хүний амь нас эрсдэх, хохирох, амиа хорлох, бага насны хүүхдийг хүчирхийлэх, эцэг, эхийн хайхрамж болгоомжгүйн улмаас амь насаа алдах эрсдэл буурахгүй байгаа тул бага насны хүүхэд гэмт хэрэгт өртөж хохирохоос урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах шаардлагатай байна.

3. Сүүлийн 5 жилд хүүхэд өртөж хохирсон гэмт хэргийн 79.3 хувийг хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг (28.2 хувь), хулгайлах (11.3 хувь), дээрэмдэх (13.7 хувь), хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгсэл ашиглалтын журмын эсрэг (8.7 хувь), бусад төрлийн гэмт хэргүүд (17.4 хувь) тус тус эзэлжээ.

Хүүхэд өртөж хохирсон гэмт хэргийн 63.3 хувь нь нийслэлд, 60.1 хувь нь гудамж талбай, гэр, орон сууцанд, 31.4 хувь нь даваа, мягмар гарагт, 37.5 хувь нь 14.00-19.00 цагийн хооронд тус тус үйлдэгдэж, 58.4 хувь нь 14-17 насны хүүхэд хохирсон хамгийн өндөр үзүүлэлт гарч байна.

Хорио цээр, хязгаарлалтын дэглэмийн үед иргэд, сургууль, цэцэрлэгийн хөдөлгөөнийг тодорхой хугацаанд үе шаттай хязгаарлаж, цагдаагийн эргүүл шалгалтыг нэмэгдүүлсэн хугацаанд хүүхэд өртөж хохирсон өмнөх онуудад хамгийн өндөр 15 хувийг эзэлж байсан хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгсэл ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 8.7 хувиар буурч, ахуйн хүрээнд үйлдэгддэг хүчирхийллийн шинжтэй гэмт хэргүүд 30.4 хувь буюу хамгийн өндөр хувийг эзэлсэн. Энэ нь иргэдийн ахуйн хүрээний архидалд буурахгүй байгааг харуулж байна.

ДҮН ШИНЖИЛГЭЭ, СУДАЛГААНЫ ХЭЛТЭС